

АЗИЙН ХӨГЖИЖ БАЙГАА ЗАРИМ ОРНЫ ҮР ТАРИАНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАЙДЛААС

Б. МЯГМАРЖАВ

Эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн

Хөгжиж байгаа орнуудын хүн амын хүнсний хангамжийг дээшлүүлэхэд үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх явдал чухал ач холбогдолтой юм. Эдгээр орны хүн амын хүнсний хангамжинд үр тариа голлох үүрэг гүйцэтгэсээр байгаа билээ.

Энэхүү өгүүллэгт Азийн хөгжиж буй орнуудын үр тарианы үйлдвэрлэлийн зөвхөн өнөөгийн байдал, түүний бүтэц, байршил, өсөлтийн хөдлөл, услах, бордох зэргээр эрчимжүүлж байгааг судалсан ажлын үр дүнгээс өгүүлэх болно.

Хөгжиж байгаа орнууд болон хөгжингүй капиталист орнуудад үр тариаг янз бүрийн зориулалтаар ашиглаж байна. Тухайлбал хөгжингүй капиталист орнуудад улаан буудайн 76 хувийг хүнсэнд, 14 хувийг малын тэжээлд хэрэглэж байхад хөгжиж байгаа орнуудад хүнсэнд 87 хувь, малын тэжээлд 2 хувийг хэрэглэж байна.¹ Ийм өөр өөр байдал нь хөгжиж байгаа олон оронд хүнс, тэжээл дутагдаж байгаатай шууд холбоотой юм.

Бид дэлхийн хүнс, тэжээл, хөдөө аж ахуйн байгууллагын материалд тулгуурлан Азийн хөгжиж байгаа орнуудын үр тарианы үйлдвэрлэлийн өнөөгийн (1960—1984 онд) байдалд судалгаа хийв.

1981 оны байдлаар Азийн хөгжиж байгаа 20 гаруй оронд нэг хүнд ноогдох нийт үр тарианы хэмжээг дараах 3 бүлэгт хуваан үзэж болно. Үүнд дэлхийн дунджаас (368 кг) дээш 1-р бүлэгт Турк, Бирм, Сири, Тайланд, Азийн хөгжиж буй орны дундаж (243 кг)-аас дэлхийн дундийн хооронд байх 2-р бүлэгт Афганистан, Индонез, Балба, Азийн хөгжиж буй орнуудын дунджаас бага (нэг хүнд 230 кг-аас ихгүй) 3-р бүлэгт Бангладеш, Бутан, Энэтхэг, Иран, Иордани, Ирак, Ливан, Малайз, Пакистан, Саудын Араб, Шри-Ланка, АБНИУ, БНАЙАУ зэрэг дийлэнх орнууд багтаж байна.

Хөгжиж буй орнуудад үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн хүн амын хүнсний хангамжийг сайжруулахын тулд авч буй арга хэмжээний нэг бол «ногоон хувьсгал» юм. Азийн орнуудын хувьд бол 1960-аад оны 2-р хагасаас «Ногоон хувьсгал» эхэлсэн² гэж үзэх явдал ч бас байдаг.

1978 онд Улаанбаатар хотноо болсон «Хөдөө аж ахуйн асуудал ба орчин үеийн үндэсний эрх чөлөөний хувьсгалд тариачдын роль» хэмээх олон улсын онолын бага хуралд зориулж «Энх тайван, социализмын асуудал» сэтгүүлийн газраас гаргасан сэдэвт «ногоон хувьсгал», түүний үр нөлөө капиталист чиг баримжаа бүхий оронд хэрхэн хөгжиж байгааг анхааран үзэх хэрэгтэй гэж үзсэн юм.³

Тухайн орон бүрийн үр тарианы үйлдвэрлэл нэмэгдэхэд зөвхөн «ногоон хувьсгал» нөлөөлсөн гэвэл учир дутагдалтай бөгөөд энэхүү арга хэмжээг Энэтхэг, Пакистан, Афганистан, Бирм, Балба, Турк, Шри-

1. М. Б. Вольф, Ю. Д. Дмитриевский География мирового сельского хозяйства М., 1981, с. 133.

2. «Зеленая революция» М., 1974, с. 5.

3. Хөдөө аж ахуйн асуудал ба орчин үеийн үндэсний эрх чөлөөний хувьсгалд тариачдын роль. УБ., 1980, 54-р тал.

Ланка, Филиппин зэрэг оронд нэлээд дэлгэрүүлэн хөгжүүлсэн байхад, нөгөө нэг хэсэг оронд хэрэглэж эхлээгүй юм уу, хэрэглэсэн ч үр дүнд хүрч чадаагүй, эсвэл үр тарианы үйлдвэрлэлийг уламжлалт хуучин аргаар эрхэлж байгаа юм.

Мөн нэгэн орны хувьд ч үзэхэд өөр өөр байгаа юм. Энэтхэг бол улаан буудай эртнээс нааш тариалж байсан уламжлалтай бөгөөд саяхан болтол га тутмаас 9 орчим центнер ургац авч байсан билээ. Гэтэл Энэтхэгийн эрдэмтэд 1960-аад оны дундуур өөрийн орны ганд тэсвэртэй сортыг бусад орны сорттой эрлийзжүүлэн шинэ сорт гаргасан бөгөөд энэ нь га тутмаас 60 ц, заримдаа түүнээс ч их ургац өгч байна. Зөвхөн Пенджаб мужид, сүүлийн 15 жилд үр тариа 4 дахин нэмэгджээ.⁴

1960-аад оны 2-р хагаст Энэтхэг, Пакистанд улаан буудайн шилмэл сорт тариалснаар га-гийн ургацыг 8,5—40 ц, Зүүн өмнөт Азид тутрагны ургац 15—43 ц, Филиппинд зарим тохиолдолд га-гаас 115 центнер авч, Бирм, Шри-Ланкад сортын үрээр тариалсан тутраканы талбай нийт талбайн 4 хувиас 44 хувьд, Балбад мөн хэмжээ 19 хувь, Энэтхэгт 38 хувьд тус тус хүрч байжээ.⁵

1981 оны байдлаар Азийн хөгжиж буй орны дүнгээр нийт үр тарианы талбайн 27,7 хувийг улаан буудай, 42,3 хувийг тутрага, 4,4 хувийг арвай, 8,2 хувийг эрдэнэшиш, 0,8 хувийг хошуу будаа, 9,7 хувийг баг будаа, 0,1 хувийг хөх тариа, 9,0 хувийг сорго тус тус эзэлж байсан.

Судалгаанаас үзвэл Афганистан, Иран, Ирак, Иордани, Пакистан, Шри-Ланка, Турк, Ливанд улаан буудай, Бангладеш, Бирм, Индонез, Малайз, Балба, Филиппин, Тайландад тутрага зонхилох таримал болж байна. Ганд ихээхэн тэсвэртэй сорго хэмээх тарималыг Саудын Арав, АБНИУ-д нийт үр тарианы талбайн 60—80 орчим хувьд тариалж байна. Харин Сирид арвайт нийт үр тарианы талбайд 50 хувь, Филиппинд эрдэнэшиш, 48 хувийг тус тус эзэлж нэлээд их хувийн жинтэй байна. 1981 оны байдлаар үр тарианы талбайн байршлыг авч үзвэл дэлхийн нийт тутрагын талбайн 89 хувь, бог будааны 55 хувь нь зөвхөн Ази тивд байршиж зонхилох байдалтай байна. Ер нь Ази тивд дэлхийн нийт үр тарианы 40 орчим хувь нь байршиж байгаа юм. Ази тивийн нийт үр тарианы талбайн 64 хувь буюу зонхилох нь үүнээс улаан буудай, тутрага, арвай, бог будаа, соргийн дийлэнх нь Азийн хөгжиж буй орнуудад байршжээ.

Азийн хөгжиж буй орнуудад ногоон хувьсгал» -ын хүрээнд хэрэгжүүлэн буй нэг үндсэн ажил бол усалгаатай талбайг нэмэгдүүлж эрдэс бордоо хэрэглэж байгаа явдал мөн. 1981 оны байдлаар дэлхийн хэмжээний усалгаат тариалангийн талбайн 63 хувь нь Ази тивд ноогдож байсан. 1961—1965 оны үед Азийн хөгжиж буй 20 орчим оронд 55732.0 мянган га усалгаатай тариалангийн талбай байсан бол, 1969—1971 оны хооронд 1961 — 1965 оны дундажтай харын уулбал 117 хувь, 1984 онд 142 хувь болж нэмэгдсэн байна. Энэ нь дэлхийн дундаж хэмжээнээс давсан үзүүлэлт юм. Гэтэл Ази тивийн хэмжээгээр 1969—1971, 1984 онд усалгаат тариалангийн талбай 1961 — 1965 оны дундаж түвшингээс нэмэгдээгүй байна.

Дээрхи хугацаанд БНАЙАУ-д усалгаат тариалангийн талбай 16 дахин нэмэгдсэн нь хамгийн дээд хэмжээ бөгөөд удаах байранд 3 дахин нэмэгдүүлсэн Бангладеш, Балба, Саудын Арав, зэрэг орон багтаж байна.

4. Газета «Правда» 16. 3. 1981 г. № 75

5. Хөдөө аж ахуйн асуудал ба орчин үеийн үндэстний эрх чөлөөний тариачдын роль. УБ., 1980, 55-р тал.

Энэтхэг, Пакистан, Иран, Индонез зэрэг 4 оронд Азийн хөгжиж буй оригуудын усалгаат талбайн 80 орчим хувь нь ноогдож байна.

Бидний судалгаанаас үзвэл, Ази тивийн дүнгээр хагалсан нэг га талбайд ноогдох эрдэс бордооны хэмжээ 1961 — 1965 оны түвшинтэй харьцуулбал 1972 онд 2, 1980 онд 5 дахин нэмэгдсэн байна. Иордан, Ливан, Шри-Ланкаас бусад Азийн хөгжиж буй орнууд дээрх хугацаанд эрдэс бордоо хэрэглэх явдал 1901 — 1965 оны түвшингээс хэд, хэдэн арав дахин ялангуяа Афганистан, Балба, Бангладеш, Бирмд ихээхэн нэмэгджээ, Харин Азийн бусад хөгжиж буй орнуудтай харьцуулбал Ливан, Малайз, Шри-Ланка зэрэг оронд 1981 онд нэг га тутамд хэрэглэх эрдэс бордооны хэмжээгээр азийн дундаж хэмжээнээс давсан байна.

Азийн хөгжиж буй орнууд 1961-1965 оны түвшинтэй харьцуулбал усалгаат талбай, эрдэс бордооны хэмжээ, шинэ сортын үр хэрэглэх зэрэг арга хэмжээ авсны үр дүнд үр тарианы үйлдвэрлэл бүхэлдээ нэлээд нэмэгдсэн байна. Тухайлбал, 1961—1965 оны түвшинтэй харьцуулбал 1969-1971, 1984 оны байдлаар нийт үр тарианы талбай 108 хувиас 118 хувь, нэг га-гийн ургац 110 хувиас 161 хувь нийт хураан авсан ургац 119 хувиас 191 хувь тус тус өсчээ. Энэ нь Ази тив болон дэлхийн дундаж хэмжээтэй ойролцоо байгаа юм.

Азийн хөгжиж буй 20 гаруй орны үр тарианы үйлдвэрлэлийн сүүлийн 24 жилийн байдлаас үзвэл Бутан, Ирак, Иордан, Ливан, АБНЙУ-д үр тарианы талбай 1961—1965 оны дундаж түвшингээс буурч, тэдгээрээс бусад орнуудад нэмэгджээ. 1984 онд Индонез, Филиппин, Бирмд үр тарианы га-гийн ургац 1961—1965 оны дундажтай харьцуулснаар Азийн хөгжиж буй орны дундаж түвшингээс дээш хэмжээнд байлаа.

Тариалах талбайг өргөтгөх замаар буюу эрчимт бус аргаар үйлдвэрлэх эсвэл га тутмын ургацыг дээшлүүлэхийн хамт тарих талбайг өргөтгөх замаар эрчимтэй хэлбэрээр нэмэгдүүлэх гэсэн 2 үндсэн хэсэгт тухайн орнуудын үр тарианы үйлдвэрлэлийг ялгаварлан үзэж болно. Тухайлбал Балбад 1969—1971, 1982 онд нийт үр тарианы үйлдвэрлэл 106--130 хувь нэмэгдсэн боловч, нэг га-гийн ургац 1961—1965 оны дундаж түвшингээс дээшээгүй байна.

1961 — 1965 оны дундажтай харьцуулбал 1984 онд Азийн хөгжиж буй орнуудын үр тарианы талбай 118 хувь, га-гийн ургац 161%, нийт хураан авсан үр тариа 191% нэмэгджээ.

Хөгжиж буй орнуудын нийт үр тарианы хураалтын дээрх түвшинээс Индонез, Саудын Арав, Филиппин, Шри-Ланка зэрэг орнууд дээгүүр өсөлттэй байна. Ер нь хөгжиж буй 10 гаруй оронд 1984 онд үр тариа хураан авах хэмжээ 1961-1965 оны дундажаас нэмэгдсэн ажээ.

1961—1965 оны дундаж хэмжээтэй харьцуулбал 1984 онд Бангладеш, Бирм, энэтхэг улаан буудай, Индонез, Сири, Филиппин тутрагын га-гийн ургац 2 дахин нэмэгджээ. Бирм, Индонез, Сири, Филиппинд тутрага, Бангладеш, Бирм, Энэтхэгт улаан буудайн га тутмын ургац Ази болон дэлхийн дундажаас дээш хэмжээтэй байгааг онцлон тэмдэглэмээр байна. Эдгээр оронд улаан буудай, тутраганы ургац нилээд өндөр хэмжээнд хүрсэн бөгөөд Сири, Иранд тутрага га тутмаас 40 ц-ээс дээш болжээ.

Харин улаан буудайн ургац буурсан юм уу эсвэл 1961—1965 оны түвшинд байгаа орнуудын дийлэнхи нь Аравын хойгийн гандуу цаг ууртай нутагт байгаа юм.

«Ногоон хувьсгал» Азийн зарим оронд үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ач тусгаа өгсөн нь эргэлзээгүй боловч дэлхийн капиталист

системийг хамарсан 1970-аад оны эхний жилүүдийн эдийн засгийн хурц хямрал, хөдөө аж ахуйд тааламжгүй цаг агаартай байсны улмаас⁶ мөн капиталист ертөнцийн үйлдвэрлэлийн харилцааны бүтцийг өөрчлөөгүй байхад «ногоон хувьсгал» нь нийгэм-эдийн засгийн тэгш биш байдлыг улам лавшруулах зэрэг⁷ байдлаас тус тус хамааран «Ногоон хувьсгал» саяарах тийшээ хандсан юм.

Тэрчлэн хөгжиж байгаа олон оронд «Ногоон хувьсгал»-ыг өргөн хүрээтэй хийх үйц нийгэм-эдийн засгийн хийгээд техникийн нөхцөл боломжгүй болохоор ганц «Ногоон хувьсгал»-ын тусламжаар хүнсний асуудлыг шийдвэрлэх үндэсгүй⁸ гэж зарим судлаачид үздэг.

Хөгжиж буй орнуудын үр тарианы үйлдвэрлэлийн өнөөгийн байдалд тал бүрээс нь дүн шинжилгээ өгч дотоод нөөц бололцоог илрүүлэх нь хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад тус дөхөм үзүүлэх нь дамжиггүй.

6. Л. А. Княжинская. Рост населения и продовольственная проблема в развивающихся странах М., 1980 с. 165—166.

7. Хөдөө аж ахуйн асуудал ба орчин үеийн үндэсний эрх чөлөөний хувьсгалд тариачдын роль. УБ. 1980. 61-р тал.

8. Мөн тэнд